



МОНЭС

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН




2007

ЖИЛИЙН ТАЙЛАН



Тэтгэлэг авагч эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүдийн үйл ажиллагаанаас



Агуулга

| | |
|--|----|
| Мэндчилгээ | 2 |
| МОНЭС-ийн Эрхэм зорилго..... | 3 |
| Тэтгэлэг олгох хөтөлбөр | |
| Сан бүрдүүлэх хөтөлбөр | |
| Тэтгэлэг олгох хөтөлбөр | 4 |
| Амжилттай хэрэгжсэн төслүүдээс | |
| 2007 оны тэтгэлэгийн санхүүжилт | |
| Сан бүрдүүлэх хөтөлбөр | 10 |
| Дотоодын хандивын мэдээ | |
| Сан бүрдүүлэлтийн үйл ажиллагаанаас | |
| Олон Улсын Сүлжээ, Хамтын Ажиллагаа..... | 13 |
| Санхүүгийн тайлан | 15 |
| Бидний тухай | 16 |
| МОНЭС-ийн хамт олон | |
| Сайн Дурын Гишүүд | |
| Шагнал урамшуулал | |
| Хандивлагчдын нэрс | 17 |
| Хандив өргөх хуудас | 24 |

Мэндчилгээ

Эрхэм найзууд аа!

Та бүхэндээ МОНЭС-ийн хамт олны нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье!

Бид амжилт бүтээл арвин ч нилээдгүй ур ухаан, эрч хүч, хөдөлмөр зүтгэл шаардсан нэгэн оныг ардаа орхилоо. Нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийг эмэгтэйчүүдийн оролцоотой бий болгоход манай сангийн оруулж байгаа хувь нэмрийг гүнээ ухамсарлан, хөрөнгө мөнгө, сэтгэл санаа, ур чадвараа зориулан дэмжигчид, зөвлөгчид болон гүйцэтгэх албаныханы чин эрмэлзэл, хичээл зүтгэлийн үр дүнд хөгжлийн нэг шатаас нөгөөд шилжих хүнд бөгөөд амаргүй ажлыг бид даван туулж байна.

Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, гадны хөрөнгө оруулалт, санхүүгийн нэмэлт эх үүсвэрүүдийг бий болгоход чиглэгдсэн олон арга хэмжээг зохион байгуулсны үр дүнд МОНЭС эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн төлөө олгодог тэтгэлэгийн хэмжээг өмнөх оноос даруй хоёр дахин нэмэгдүүлж чадлаа.

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хөдөлгөгч хүч болсон эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүд тогтвортой хөгжих нь нийгмийн өөрчлөлтийг авчирах гол хүчин зүйлүүдийн нэг гэж бид үздэг. Бид бүлгүүдэд

тэтгэлэг олгохдоо стратегийн ач холбогдолыг чухалчилсан ба орон нутаг болоод үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүдийг эвсэл, сүлжээгээр хамтран ажиллах үйл явцыг дэмжсэнээр бодит тоон болон чанарын үр дүн гарч байна. Үүний тулд тэтгэлэгийн хөтөлбөрийн болон санхүүгийн бодлогуудыг чанаржуулан шинэчиллээ.

Сан бүрдүүлэх хөтөлбөрийг сайжруулахад олон улсын зөвлөхүүдийн удаа дараагийн сургалт, заавар зөвлөмж нь ихээхэн үр өгөөжөө өгч байна. Мөн бусдын сайн сайхны төлөө хандив өргөх филантропи сэтгэлгээг нийгэмд төлөвшүүлэх, тэтгэлэг авагч эмэгтэйчүүдийн бүлгүүдийн чадавхыг дээшлүүлэх зэрэг зайлшгүй хэрэгтэй нэмэлт ажлуудыг хийсээр ирлээ.

Байгууллага маань өсөн дэвжихийн хирээр хүний нөөц нэмэгдэж, бодлого, хөтөлбөрүүдэд туслах дүрэм журмуудыг шинэчлэх, ажилтануудын чадвар дадлагыг нэмэгдүүлэх шаардлага ар араасаа урган гарч ирсээр байна.

Ирэх онд хуучин амжилтаа бататгаж, шинэ үр өгөөжтэй бүтээлээр эргэн уулзацгаая.

МОНЭС-ийн сайн сайхан хөгжлийн төлөө байнга хамт байдаг бүх хүмүүс, байгууллага хамт олонд дахин талархсанаа илэрхийлье!



Ш.Цэвэлмаа
МОНЭС-ийн Тэргүүн
МУ-ын Анхны Тэргүүн хатагтай



Н.Чинчулуун
Захирал
Үүсгэн байгуулагч

Эрхэм зорилго:

Монголын эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө нөөц баялагийг хуримтлуулж санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/ 2000 онд байгуулагдсан ба улс төрийн нам, эвслээс хараат бус, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг олон нийтийн сан юм.

Манай сан нийгэмд үйлчилдэг эмэгтэйчүүдийн ТББ, эмэгтэй удирдагчтай хүний эрхийн ТББ, үүсгэл санаачлагын бүлгүүдийн эмэгтэйчүүдийн эрх, эмэгтэйчүүдийн оролцоо, хөгжлийг хангахын төлөө үйл ажиллагааг дэмжиж санхүүгийн буцалтгүй тэтгэлэг олгодог филантропи /нийгмийн хөгжлийн төлөө мөнгөн тусалцаа үзүүлдэг/ байгууллага юм.

Бидний итгэл, үнэт зүйлс:

- Эмэгтэйчүүд хүчтэй, чадвартай.
- Эмэгтэйчүүд нэгдсэнээр амжилтанд хүрнэ.
- Хүний эрхийг жинхэнэ ёсоор дээдэлсэн шудрага, ардчилсан иргэний нийгмийг эмэгтэйчүүдийн оролцоо, хандивгүйгээр төсөөлж үл болно.
- Эмэгтэйчүүд нийгмийг өөрчилж чадна.
- Ил тод, шудрага ёсонд итгэдэг.
- Хүн бүхэн бусдын сайн сайхны төлөө хандивлагч байж чадна.

ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

Энэ хөтөлбөрийн зорилго нь эмэгтэйчүүдийг чадавхижуулах замаар нийгмийн өөрчлөлт хийх явдал юм. Үүний тулд дараах чиглэлээр төслүүдийг санхүүжүүлнэ,

- Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт ба хүчирхийлэлтэй тэмцэх,
- Шийдвэр гаргах түвшин дэх Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх,
- Давхар бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадваржуулах замаар тэдний нийгмийн байдлыг сайжруулах,
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх,

САН БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Энэ хөтөлбөрийн зорилго нь эмэгтэйчүүдийн эрхэд суурилсан нийгэмд үйлчилдэг Эмэгтэйчүүдийн ТББ ба бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжихийн тулд дотоод, гадаадын эх-үүсвэрээс сан бүрдүүлнэ.

Үүний тулд:


- Филантропи үзэл хандлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, төлөвшүүлэх,
- Сан бүрдүүлэх олон талт ажлуудыг зохион байгуулж, хандив цуглуулах,

Тэтгэлэг олгох хөтөлбөр

2007 онд 17 төсөл хөтөлбөрт нийт 166,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.


Үүнд:

1. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах ба хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 9 төсөлд (нийт тэтгэлэгийн сангийн 78,7%),
2. Давхар бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадваржуулах 2 төсөлд (7,8%),
3. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх 6 төсөлд (13,5%).



Дүрс зураг 1. 2007 онд олгогдсон тэтгэлэг

2001-2007 онд 132 төсөл, хөтөлбөрт нийт 382,5 сая төгрөгийн санхүүжилт олголоо.



Дүрс зураг 2. МОНЭС-гаас 2001-2007 олгосон тэтгэлэгийн мөнгөн дүн болон байгууллага, бүлгүүд

Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс хамгаалах

1. Гэр бүлийн хүчирхийллээс охид, эмэгтэйчүүдийг хамгаалахад олон нийтийг оролцуулах нь:

"Хүчирхийллийн нийгэм эдийн засгийн өртөг" судалгаанд оролцсон хөдөөгийн эмэгтэйн ярианаас:

Гэрлэлтийн эхний жилүүдэд ханьтай, охинтой болж, амьдрал тэр чигээрээ сайхан байх юм шиг санаж байсан. Гэрлэсний дараа 5 дах жилээс эхлэн нөхөр маань зоддог болж, 14 жилийн турш ийм байдалтай байна. Өөрөө их бухимдуу боллоо. Нөхөр их ууртай, танхай болохоор аргаар нь л байдаг байсан.

Хэд хэдэн удаа нөхрөөсөө зугтан өөр газар очиж амьдарсан. Ганц өмссөн хувцастайгаа зугтаж байгаа болохоор шинэ газар очоод суурьшихад маш их зардал гаргадаг.

Тэгээд нэгээс нөгөө рүү нуугдах төлөвлөгөө боловсруулж эхэлдэг. Энэ хугацаанд ах дүү хамаатан садантайгаа холбоо тасарсан, ээжтэйгээ жилдээ нэг удаа уулздаг.

Зөвхөн эд материалын төдийгүй, сэтгэл санаа, эрүүл мэндийн хувьд ч их хохирдог. Хандсан газар тэр бүр хамгаалдаггүй.

Цагдаа өөрсдөө асуудлаа зохицуул гэдэг эсвэл нөхрийг хэд хоног баривчилдаг.

Бүх хэлбэрийн хүчирхийлээс хамгаалах үүрэгт хохиролчдод хууль зох зүйн зөвлөгч, холбогдох бусад үйлчилгээ үзүүлэх үүрэгт хүчирхийлэлчдэд хариуцлага хүлээлгэх үүргийг Засгийн газар хариу ёстой. Манай оронд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хууль батлагдаад тэдэн жил орж байгаа ч гэр бүлийн хүчирхийлэлээс охид, эмэгтэйчүүдээ хамгаалж чадахгүй байна.

Баг, хорооны засаг дарга, эмч, цагдаа, нийгмийн ажилтан зэрэг "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий албан хаагчдыг оролцуулсан "Хамтарсан баг"-ийг Завхан, Өмнөговь аймагт ажиллуулах чиглэлээр Хүчирхийллийн эсрэг Үндэсний Төвийн саналыг дэмжлээ.

Төслийн хүрээнд Хамтарсан багийн гишүүд мөн сэтгэл зүйн зөвлөгч, сургагч багш нарыг бэлтгэн, хуулийг олон нийгэд таниулах, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүүхэд, эмэгтэйчүүдтэй ажиллаж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг 43 хүнд үзүүлж тухайн аймгуудад хууль хэрэгжүүлэхэд олон нийтийг оролцуулах эхлэл тавигдлаа.

Мөн Завхан аймгийн Хамтарсан багийн гишүүд хүүхдийнхээ хажууд эхнэрээ хүчирхийлдэг нөхрийг хуулийн хариуцлага хүлээлгэхэд холбон зуучлах, эцэгтэйгээ нийлж эхийгээ дарамталдаг залууг анги,

хамт олноор нь дамжуулан нөлөөлөх ажлыг зохион байгуулжээ.

Улаанбаатар хот, Завхан, Өмнөговь аймгийн 125 эмэгтэйн дунд хийсэн "Гэр бүлийн хүчирхийллийн нийгэм-эдийн засгийн өртөг" судалгаанаас үзвэл гэр бүл дэх хүчирхийлэл нь тухайн гэр бүлийн амьдралыг бусниулахын гадна ядуурлыг нэмэгдүүлдэг байна. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд ажлаас халагдаж, эвдэрсэн эд хогшил, урагдсан хувцас шинээр авах, гэрээсээ хөөгдөн гадуур хонох зэрэг нэмэлт зардал тогтмол гарахаас гадна, эрүүл мэнд, сэтгэл санаагаар байнга хохирдог байна.

2. Ажлын байран дахь бэлгийн дарамтлал

Ажлын байран дахь бэлгийн дарамт бол хүйсээр ялгаварлан гадуурхах нэг хэлбэр ба хүний нэр төр, амжилт, амьжиргаа, эрүүл мэнд мөн хөдөлмөрийн бүтээмжтэй холбоотой байдаг. Хоёр эмэгтэйн нэг нь ажлын байран дахь бэлгийн дарамтлалд (АББД) өртдөг гэсэн таамаг байдаг ч эмэгтэйчүүд, ажил олгогчдын энэ талаархи ойлголт хангалтгүй байна. АББД гэдгийг зөвхөн “хүчин” гэж олон нийт ойлгож, түүнээс өмнөх олон үйлдлийг ойшоохгүй байна. Хохирогчид нь хаашаа хандахаа мэддэггүй.

Ажлын байран дахь бэлгийн дарамтыг зогсоох асуудлаар эмэгтэйчүүдийн төрийн бус 16 байгууллага нэгдэн эвсэл байгуулан ажиллаж байна.

АББД-ын талаар эмэгтэйчүүд, ажил олгогчид, олон нийтийн ойлголт ямар байгааг тандсан судалгаанаас үзвэл ажлын байрандаа бэлгийн дарамтад өртсөн эмэгтэйчүүд хуулийн байгууллагад хандаж хохирлоо барагдуулсан тохиолдол бараг байдаггүй ба хандсан нөхцөлд үүнийг нь шийдвэрлэх хууль эрх зүйн орчин байхгүй байгааг тогтоосон юм.

“АББД-ыг зогсооё” сэдэвт ЭТББ-ын эвслийн энэ төсөл хууль эрх зүйн орчинг бий болгохыг зорьсон ба энэ талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг бүрдүүлэх үүднээс үндэсний болон орон нутгийн 450 сургагч багшийг бэлтгэн нийт 5000 эмэгтэйчүүд, ажил олгогчдод таниулах ажил хийж байна.



3. Бэлгийн хүчирхийллээс охид, эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх, хамгаалах

Өсвөр насандаа ээж болсон мөн бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидыг хамгаалах, дахин эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх цогц үйлчилгээ бий болгох асуудал МОНЭС-ийн анхаарлын төвд байдаг.

Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийн “Хүүхэд хамгаалах байр”-ны энэхүү төсөл орон гэрээсээ дайжиж, хамгаалалтанд нь хамрагдсан 4-18 насны 52 хүүхдэд нийгмийн ажил, сэтгэл зүй болон хууль эрх зүйн зөвлөгөө үзүүлжээ. Эдгээр хүүхдийн 11 нь бэлгийн хүчирхийллийн, түүний дотор 6 нь ураг төрлийн хүчингийн хохирогч охид байна. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн талаар ойлголттой болгож, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана, хэнд хандах, ямар тусламж авах талаар мэдлэг, чадварыг эдгээр охид, тэдний ээжүүдэд олгож, хүчирхийллээс өөрсдийгөө хамгаалах, бие биендээ

туслах, бэрхшээлийг хамтран даван туулах дэмжих бүлгийг байгуулан ажиллуулж байна.

Жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн 19 хүртэлх насны охидод тулгарч буй нийгмийн, сэтгэл зүйн олон бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, тэдгээр охидыг чадваржуулах, өрхийн амьжиргаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх хэрэгцээ шаардлага манай өнөөгийн нийгэмд байсаар байна. “ГҮНЖ” төв өсвөр насны залуу эхчүүдийг чадваржуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж тэдэнд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө болон нийгмийн ажлын цогц үйлчилгээ үзүүлдэг.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн амьдралын талаарх ойлголт, мэдлэг дутмагаас

Шигтгээ:

“ГҮНЖ” төвийн судалгаанаас үзвэл 2007 онд төрсөн эхчүүдийн 7% нь буюу 4000 орчим нь өсвөр насны охид (15-19 насны) байжээ.

Дээрх тоог өмнөх онтой харьцуулбал 1.7 мянгаар нэмэгджээ. Өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлт улсын хэмжээнд харьцангуй буурах хандлагатай байгаа гэж мэргэжлийн байгууллагууд үздэг ч 2007 онд нийт төрөлтийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор тэдний төрөлт ч мөн нэмэгдсэн байна.



Зураг 1. Залуу эхчүүд, тэдний хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх Өлөр өнжүүлэх үйлчилгээний төв ба төвөөр үйлчлүүлэгчид

өсвөр насны охид жирэмсэлж, хүүхэд төрүүлдэг. Согтууруулах ундааны хэрэглээ залуучуудын дунд их байгаагаас согтуу байдалд жирэмсэлсэн охидын тоо сүүлийн жилд нэмэгдэж байна. Мөн бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас жирэмсэлж, хүүхэд төрүүлсэн цөөн тохиолдол байна.

“ГҮНЖ” төв өсвөр насны залуу эхчүүдэд тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд, хэрэгцээ шаардлага зэргийг судалсны үндсэн дээр халамж, үйлчилгээний өдөр өнжүүлэх төвийг 2007 онд байгуулан ажиллаж байна. Төв нь 15-20 хүүхдийн багтаамжтай ба залуу эхчүүд, тэдний 1-4 насны хүүхдэд цогц үйлчилгээ үзүүлдэг. 2007 онд Сүхбаатар дүүрэгт харьяалалтай, хүнд нөхцөлд амьдардаг, өрхийн орлого багатай залуу эхчүүдэд үйлчилж, тэднийг чадваржуулахаар ажиллаж эхлээд байна.

4.Эмэгтэйчүүд ба хэвлэл мэдээлэл

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан, дорд үзсэн, тэдний эрхийг зөрчсөн аястай мэдээлэл ихээр цацагддаг. Хэвлэл мэдээллийн ажилтнуудын хүний эрхийн мэдлэгийг нэмэгдүүлж, охид эмэгтэйчүүдийг садар самуунд уруу татах сурталчилгааг зогсоох нь эмэгтэйчүүдийн өмнө тулгамдсан чухал асуудал хэвээр байна.

Манай нийгмийн өмнө тулгамдаж байгаа асуудлын нэг бол хэвлэл мэдээлэлд хүний эрхийг дээдлэх явдал гэж 2007 оны 3-р сард болсон “Эмэгтэйчүүдийн Хүчээр - Эмэгтэйчүүдийн Нүдээр” Чуулган үзсэн. Иймд эмэгтэйчүүдийн эрхийн төлөө байгууллага, хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хэвлэл мэдээллээр хүний эрхийг зөрчдөг байдлыг арилгах зорилгоор ЭТББ-ын Үндэсний сүлжээ /ЭТББҮС/-г дэмжиж ажилласан. Төслийн хүрээнд Монголын Үндэсний олон нийтийн телевиз, С1 телевиз, ФМ 101,7 радио, “Өдрийн сонин”, “Хүмүүс” сонинг сонгон, тэдний нийтлэл, нэвтрүүлэгт дүн шинжилгээ хийж, эмэгтэйчүүдийн хүний эрхийн талаар бодлого үгүйлэгдэж байна гэж төслийн баг дүгнэсэн юм. Хэвлэл мэдээллийн нийтлэл,



Зураг 2. “Хэвлэл мэдээлэл ба эмэгтэйчүүд” төслийн судалгааны багийн гишүүдийн уулзалт

нэвтрүүлгийн бодлогод нөлөөлөх зорилгоор сэтгүүлчдийн дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж улмаар “хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй”-г төлөвшүүлэх эхлэл тавих юм.

Мөн “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилж байгаа өнөөгийн байдал” судалгаа хийх МУИС-ийн судлаачдын багийг дэмжлээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр охид эмэгтэйчүүдийг садар самуунд уруу татсан нийтлэл, нэвтрүүлэг, мэдээ, зар олноор нийтлэгдэж байгаа нь мэдээллийн хэрэгслүүд хууль зөрчиж, улмаар охид, эмэгтэйчүүд гэмт хэргийн хохирогч болж, бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байгааг тогтоосон юм. Мөн телевизүүдийн “Чат” сувгаар явж байгаа заруудаар биеэ үнэлэхийг санал болгосон, уриалан дуудсан зарууд их байгаад үүрэг хүлээгчдийн анхаарлыг хандуулж, улмаар “Садар самуунтай тэмцэх тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байгааг судалгааны дүн харууллаа.

Энэ хөтөлбөрийн хүрээнд олгосон тэтгэлэг

Хүснэгт-1

| Төслийн нэр | Тэтгэлэг авсан байгууллага | Санхүүжилт/төг/ |
|---|---|--------------------|
| Өсвөр насны охид, тэдний 1-4 насны хүүхдүүдэд зориулсан Өдөр өнжүүлэх халамж, үйлчилгээний төв байгуулан ажиллуулах | Охид залуу эхчүүдийн эрхийг хамгаалах "Гүнж" төв | 28 298 088 |
| Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, хүүхдийн эрхийг хамгаалах, эерэг орчин бүрдүүлэх хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжих | ХЭҮТ-ийн "Хүүхэд хамгаалах нэгж" | 15 875 920 |
| Гэр бүл дэх-хүчирхийллийн нийгэм эдийн засгийн өртөг судалгаа /Завхан, Өмнөговь, Улаанбаатар хот/ | МУИС-ийн Судлаачдын баг | 5 251 999 |
| Хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилж буй байдал тандалтын судалгаа | Ойлт ТББ | 2 501 538 |
| Завхан, Өмнөговь аймагт "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийг хэрэгжүүлэх нь | Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв | 5 855 687 |
| Цэрэг болон цэрэгжсэн байгууллагуудад ажиллаж байгаа энгийн албан хаагчдын ялгаварлалыг багасгах нь | Цэрэг болон цэрэгжсэн эмэгтэйчүүдийн "Бэр цэцэг холбоо" | 2 491 000 |
| Ажлын байран дахь бэлгийн дарамт-З | ЭТББ-ын эвсэл –Нисора сан | 25 000 000 |
| Ажлын байран дахь бэлгийн дарамт хуульчдын хэлэлцүүлэг | Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо | 1 500 000 |
| Эмэгтэйчүүдийн эрх ба хэвлэл мэдээлэл | Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын Үндэсний сүлжээ | 44 348 678 |
| | Дүн | 131 122 910 |

Давхар бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадваржуулах

Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг чадваржуулах нь нийгэмд өөрчлөлт авчрах чухал арга зам гэж МОНЭС үздэг.

Энэ чиглэлийн төслүүд нь давхар бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг багаар хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэхийг зорьдог. 2007 онд ийм төслүүд Завхан, Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотын Багануур, Сүхбаатар дүүргийн нийт 150 эмэгтэйг хамарсан.

Давхар бэрхшээлтэй эмэгтэйчүүд гэдэгт:

- Өрх толгойлсон, олон хүүхэдтэй
- Хөгжлийн бэрхшээлтэй, хүнд нөхцөлд амьдардаг,
- Ажилгүй, ядуу
- Хүчирхийлэлд өртсөн, гэрээсээ дайжсан

- Өсвөр насандаа хүүхэд төрүүлсэн, ажил мэргэжилгүй,
- Орлогогүй, нас, хүйсээрээ ялгаварлагдаж байгаа зэрэг хэд хэдэн бэрхшээл давхар нүүрлэсэн эмэгтэйчүүдийг хамааруулдаг.

Төсөл хэрэгжүүлсний үр дүнд:

- Эмэгтэйчүүд баг болон ажиллах чадвар нэмэгдсэн
- Ижил төрлийн асуудалтай эмэгтэйчүүд бие биендээ туслах сэтгэл, арга барил олсон
- Бүлгээрээ хөдөлмөрийн хуваарь гаргаж ажилласнаар бүтээгдэхүүний чанар дээшилж, зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэж байна.
- Зөвхөн өөрсөддөө орлого олох биш тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт байгаа зөрчлийг ил гарган, шийдвэрлэх арга хэмжээг хамтран авч байгаа нь орчноо сайжруулж, өөрчлөх идэвхийг өрнүүлж байна.



Зураг 3. Сүхбаатар дүүргийн 16-р хорооны бүлгийн гишүүд

Энэ хөтөлбөрийн хүрээнд олгосон тэтгэлэг:

Хүснэгт-2

| Төслийн нэр | Тэтгэлэг авсан байгууллага | Санхүүжилт/төг/ |
|--|----------------------------|-------------------|
| Хамт олны чадавхийг хөгжүүлэх нь | Хууль ба Хүний эрх | 9 906 724 |
| Эмэгтэйчүүдийн бүлгүүдийн хийж байгаа бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх | Дүүрэн санаа | 3 030 000 |
| | Дүн | 12 936 724 |

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх

Хүний эрхийг жинхэнэ ёсоор дээдэлсэн шудрага, ардчилсан нийгмийг эмэгтэйчүүдийн оролцоотойгоор, тэдний хөдөлгөөний оновчтой нөлөөллөөр байгуулна

А. Үндэсний хэмжээн дэх үйл ажиллагаа

- Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын Үндэсний сүлжээний ажлын албыг дэмжсэнээр Сүлжээний үйл ажиллагааг эрчимтэй явуулах нөхцлийг бүрдүүлсэн.
- Эвсэл, сүлжээгээр хамтран ажиллах замаар нөлөөлөл, дуу хоолойгоо хүчтэй болгох боломжийг бий болгож байна.
- Хөдөлгөөний оролцогч, дэмжигчдийн хурал, уулзалт, чуулганыг дэмжсэнээр тэдний хамтын ажиллагааг сайжруулах боломжийг нэмэгдүүлж байна.

Б. Орон нутгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа.

Завхан, Өмнөговь, Өвөрхангай аймаг, Багануур дүүргийн ЭТБ-уудын хамтран ажиллах чадварыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллалаа. Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ганц нэгээрээ биш нэгдэн ажиллах нь илүү үр дүнтэйг харуулж буй Завхан, Өмнөговь, Багануур дүүргийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд 5-11 байгууллагыг эгнээндээ нэгтгэн ажиллаж байна. Эдгээр сүлжээ орон нутгийн эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх стратеги, чиглэлээ тодорхойлжээ. Үүнд:




- Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх,
- Хүчирхийллийн эрсдэлтэй гэр бүл, эмэгтэйчүүдийг хамгаалах,
- Ядуу, олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийг хамтран дэмжих.

Энэ хөтөлбөрийн хүрээнд олгосон тэтгэлэг:

| Төслийн нэр | Тэтгэлэг авсан байгууллага | Санхүүжилт/төг/ |
|---|---|-------------------|
| Эрүүл мэндийн байгууллагын төсөв-эмэгтэйчүүдийн нүдээр | Өвөрхангай аймгийн "Орон нутгийн санаачлага" ТББ | 7 104 500 |
| Байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь | Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын Үндэсний сүлжээ | 5 825 000 |
| Эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх нь | Багануур дүүргийн ЭТББ-ын сүлжээ | 5 541 000 |
| ЭТББ-ын чадавхжуулах суралцах аялал | Өмнөговь аймгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд | 1 079 817 |
| Байгууллагын чадавхи бэхжүүлэх | Эмэгтэйчүүд -Амьдрал | 500 000 |
| Эмэгтэйчүүдийн хүчээр эмэгтэйчүүдийн нүдээр Чуулган | Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын Үндэсний сүлжээ | 2 431 060 |
| | Дүн | 22 481 377 |

САН БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

2007 онд дотоодын эх үүсвэрээс **10.52** сая төгрөг, гадаадаас **290,9** сая төгрөг буюу нийтдээ **301.4** сая төгрөгийн тэтгэлэгийн сан бүрдүүллээ.



Дүрст зураг-1. Дотоодын сан бүрдүүлэлт 2001-2007/төг/

“Эмэгтэйчүүдийн нүдээр-Эмэгтэйчүүдийн хүчээр” Үндэсний чуулганы үеэрхи ХАНДИВ ЦУГЛУУЛАЛТ, 2007.03.07

З дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа энэхүү Үндэсний чуулганы үеэр өөрсдийн, үйл ажиллагаагаа сурталчилан хандив цуглуулсан юм.



88 ӨДРИЙН АЯН

Олон улсын Хүний эрхийн өдөр 12 сарын 10 наас Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр 3 сарын 8 хүртэл 88 өдөр.

88 өдрийн сан бүрдүүлэх аяныг 3 дахь жилдээ зохион байгууллаа. 2007 оны аяныг "Охид, эмэгтэйчүүдийг садар самуунд уруу татсан сурталчилгааг зогсооё" уриан дор зохиов.

Тус аянд 483 хувь хүн, 34 байгууллага оролцож 2.689.600 төгрөгийн мөнгөөр, 1.287.900 төгрөгийн мөнгөн бусаар ивээн тэтгэсэн. Хандивлагчдын хонжвор болох Бээжин очиж ирэх тийгийг Дорноговь аймгийн Төмөр Замын ажилтан н. Шинэхүү хожлоо.



ХАНДИВЫН ХАЙРЦАГ

Бид ХААН Банктай хамтран 3 жил зохион байгуулж байгаа энэ аян "ТАВАН ХҮҮХДИЙН ТЭТГЭМЖИЙН МӨНГӨ 15000 ТӨГРӨГӨӨР ТА ХҮҮХДҮҮДЭЭ БҮТЭН САР ТЭЖЭЭЖ ЧАДАХ УУ?" сэдвийн дор 2007 онд явагдлаа. ХААН Банкны 23 салбарт байрлуулсан хандивын хайрцагар цугларсан 598 440 төгрөгийг өрх толгойлсон олон хүүхэдтэй ээж нарт гэрээр хөдөлмөр эрхлэхэд зориулна.



ТАЛАРХАЛ

Бидний үйл хэргийг дэмжиж эмэгтэйчүүдэд хувь нэмэр оруулж байгаа хандивлагч хувь хүмүүс, байгууллага хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

88 өдрийн аянг ивээн тэтгэсэн хандивлагч байгууллагуудын нэрс:

- Эйр Транс агаарын нислэгийн агентлаг
 - Lady төв
- Интерпресс хэвлэлийн компани
- Америк Монголын Хамтарсан Сантис Боловсролын төв
 - Боловсрол Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
- MED Esthetica гоо сайхны салон
 - Монфорте ХХК
 - МОНОС Улаанбаатар ХХК
 - МУБИС Биеийн Тамирын Дээд Сургууль
 - UB Bulls чийрэгжилтийн клуб
 - Гүрэн зоогийн газар
 - Талын Монгол зоогийн газар
 - Akdeniz зоогийн газар
 - Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэгийн дэргэдэх эмэгтэйчүүдийн гар урлалын бүлгүүд
 - Монголын Уран Зургийн Галарей
 - Батбайгаль ХХК
 - Олон Улсын Хүүхдийн төв "Найрамдал" зуслан

ТАЛАРХАЛ

Хандивын хайрцагны аянд оролцож өгөөмөр сэтгэлийн хандив өргөсөн, Хаан Банкны хамт олон, түүний байнгын үйлчлүүлэгч Та бүхэндээ эмэгтэйчүүдийнхээ нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.



Олон улсын ФИЛАНТРОПИ ӨДӨР /2007.11.01-11.15 /

Олон улсын Филантропи өдрийг Монголд 5 дахь жилдээ зохион байгууллаа.

2007 оны 11 сарын 1-нээс 15 ны хооронд “Өрх толгойлсон, олон хүүхэдтэй ээжүүдийг хөдөлмөр эрхлүүлж, ядуурлаас гаргахад хандив өргөгчөө” гэсэн уриан дор филантропи өдрийг тэмдэглэсэн. Энэ аяны хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран дараах үйл ажиллагааг зохион явуулав:



1. “Филантропийн хөгжилд сэтгүүлчдийн оруулах хувь нэмэр” сургалт. Уг сургалтанд 11 телевиз, 7 сонин, 2 FM радиогийн 18 сэтгүүлч хамрагдав.

2. “Филантропи нийгмийг өөрчилнө” номын удаах хэвлэлийг танилцуулах номын нээлтийн өдрөөр Хэвлэлийн Бага хурал хийв.

3. Сан бүрдүүлэх “ТВ Телетон” шууд нэвтрүүлэгийг SBN, UBS телевизээр орон даяар 3 удаа явуулав. Эдгээр нэвтрүүлэгээр өмнөх онд ТВ-ээр цуглуулсан мөнгөөр юу хийснээ мэдээлж, Филантропийн талаарх ойлголтыг тайлбарлан сурталчилж, олон үзэгчдээс хандив цуглууллаа.

Телетон нэвтрүүлэгт үнэтэй хувь нэмэр оруулсан иргэний нийгэм, соёл, урлагийн алдартанууддаа талархал илэрхийлье.

С.Ганбаатар /МУЭХолбооны Ерөнхийлөгч/
Д.Энхжаргал /Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төвийн Захирал/
Л.Бадамцэцэг / Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төвийн ажилтан/
Ж. Занаа /Иргэдийн Альяанс төвийн захирал/

Ц.Жадамбаа /Глобал удирдагч сангийн Захирал/
Б. Мөнхбат /SBN телевизээр хөтлөгч/
Л.Чаминчулуун /МУГЖ/
Н.Энхбат /СТА дуучин /
Д.Өнөрбаатар /Нюанс хамтлагын ахлагч, дуучин/
Чапи буюу Ихбаяр /СТА жүжигчин/

4. 2007 оны 11 дүгээр сарын 15-нд Филантропи өдрийн хүндэтгэлийн хүлээн авалтыг Улаанбаатар рестораны “Хархорум” танхимд зохион байгууллаа. Хүлээн авалтанд 80 хүн оролцож 1.2 сая төгрөгний хандив өргөлөө.

5. Мөн байнгын хандивлагч нартаа Талархлын Хуудас гардуулж урамшууллаа.



ФИЛАНТРОПИ ГЭЖ ЮУ ВЭ?

Филантропи нь грек хэлний гаралтай үг юм. “Фила” гэж “хайр”, “тропи” гэж “хүн” гэсэн үгнээс “хүнийг хайрлах хайр” гэсэн үг юм. Орчин үед Филантропи гэсэн үг нь “бусдыг хайрлаж туслахын тулд хандив өргөх” гэсэн утгыг илэрхийлдэг.

ФИЛАНТРОПЧ гэдэг нь бусдын сайн сайхны төлөө цаг зав, оюун ухаан, хөдөлмөр, хөрөнгө мөнгөө хандивлагч хүнийг хэлнэ.

МОНГОЛЧУУДЫН ФИЛАНТРОПИ СЭТГЭЛГЭЭ:

Монголчууд бидний бие биендээ туслах уламжлалт харилцаа их онцлогтой байжээ. Нүүдлийн соёл иргэншилтэй бид “харилцан тусалцах” хэмээх чухал ойлголтыг дан ганц ураг төрлийн хэлхээтэй холбон үзэж байсангүй. Энэ нь таньдаг, таньдаггүй, хар элгийн хүмүүсийн харилцаанд ч байдаг байжээ.

Бид “ХҮНД ТУС ХИЙВЭЛ ӨӨРТ ТУС ИРНЭ”, “САЙН САНААНЫ ҮЗҮҮРТ ШАР ТОС”, “БУЯН БУЦААД ИРНЭ” хэмээн зүйр цэцэн үгэнд шастирлаж, үр хүүхдийнхээ ой тойнд гүн бат шингээн хүмүүжүүлэх арвин туршлагатай, шилдэг өв уламжлалтай ард түмэн.

ТАЛАРХАЛ

Сан бүрдүүлэх Телетон нэвтрүүлгийг амжилттай хийхэд гүн тусалцаа үзүүлсэн МОНЭС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, SBN Телевизийн ерөнхий продюсер Н.Дуламсүрэндээ гүн талархал илэрхийлье.

ОЛОН УЛСЫН СҮЛЖЭЭ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

МОНЭС нь үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн Олон Улсын 6 байгууллагад гишүүнээр ажиллахдаа тэдгээрийн туршлагыг судалж нэвтрүүлэх, Монголын эмэгтэйчүүдийн хөгжил дэвшил, тулгарч байгаа асуудал, бэрхшээлийн талаар танилцуулж, шийдвэрлэж буй арга зам, туршлагаа харилцан солилцож ирлээ.

Сүлжээ байгууллагын нэрс:

- ОУ-ын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ/INWF/
- Америкийн Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ /WFN/
- Азийн Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ /AWFN/
- Хил Хязгааргүй Тэтгэлэг Олгогч Байгууллага/GWOB/
- Хөгжлийн Төлөө Эмэгтэйчүүдийн Олон Улсын Холбоо/AWID/
- Хүний Эрхийн Сангуудын Сүлжээ/HRFN/


2007 онд МОНЭС-ийн төлөөлөгчид олон улсын сүлжээний 4 хуралд оролцлоо.

Азийн Бүсийн Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээний уулзалт, 2007 оны 3 сар, Непалын Катманду хот



Непалын TEWA, Хонг Конгын HER Fund, Энэтхэгийн Nirnaya, Монголын MONES зэрэг сангийн энэхүү Сүлжээний уулзалтанд Сан бүрдүүлэх Хөтөлбөрийн Захирал Л. Болор, Сан бүрдүүлэх хөтөлбөрийн зохицуулагч Б. Байгалмаа нар оролцлоо. Энэхүү хурлаар Азийн Бүсийн Эмэгтэйчүүдийн Сангууд өөрсдийн сан бүрдүүлэлт, тэтгэлэг олголтын амжилт, бэрхшээлийн талаар харилцан ярилцаж туршлагаа солилцон цаашдаа хамтран ажиллах төлөвлөгөөг батласан.

Сан бүрдүүлэх сургалт, 2007 оны 4 сар, Улаанбаатар хот



2007 оны 4-р сард болсон 5 хоногийн энэхүү сургалтыг Нидерландын ОУ-ын зөвлөх Диана ван Масдижк, Нидерландын Мама Каш сангийн мэргэжилтэн Ёландо Яансэн нар МОНЭС-ийн ажилтан, Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулан явуулав. Сургалтанд гадаадаас болон дотоодоос хэрхэн сан бүрдүүлэх арга техник, бодлого, гадаадын болон олон улсын эмэгтэйчүүдийн сангуудын туршлага зэрэг сэдвийг хамарлаа. Мөн МОНЭС-ийн сан бүрдүүлэлтийн стратегийг үнэлж, зөвлөлгөө өгсөн нь бидний ур чадварыг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр боллоо.

Дэлхийн Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээний хурал, 2007 оны 5 сар, АНУ, Сиатл хот



Хуралд тэтгэлэг олгох хөтөлбөрийн зохицуулагч Л.Номин, санхүү хариуцсан ажилтан С.Цэрэнпүрэв нар оролцлоо. Энэ хурлаар ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийг дэмжих хоёрын хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлын талаар нээлттэй, дэлгэрэнгүй санал солилцлого явагдлаа.



Олон Улсын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээний хурал, 2007 оны 5 сар, ОХУ, Ялта хот



Захирал Н. Чинчулуун, Тэтгэлэг олгох хөтөлбөрийн зохицуулагч Л. Номин нар оролцож “МОНЭС-ын Стратегийн Тэтгэлэг Олголт” сэдвээр илтгэл тавьсан. Сангуудын төлөөлөгч нар өөр өөрийн орны сан бүрдүүлэлт, тэтгэлэг олголтыг оновчтой, үр ашигтай болгох талаар туршлагаа солилцсон. Шинээр



сүлжээнд элсэж байгаа Недерландын “Women Win”, Арабын Эмэгтэйчүүдийн санг найр тавин хүлээн авлаа.

2009 оны Олон Улсын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ /INWF/-ний ээлжит хурлыг Монголд МОНЭС зохион байгуулна.

Хил Хязгааргүй Тэтгэлэг Олгогчид байгууллагын 2007 оны уулзалт, 6-р сар, АНУ, Нью-Йорк хот


Энэ уулзалтанд Сан бүрдүүлэх Хөтөлбөрийн Захирал Л. Болор, сайн дурын зөвлөх Др. Шелдон Северинхаус нар оролцлоо. Уулзалтаар тэтгэлэг, санхүүжилт олгох дэлхийн, болон бүс нутгийн орчны өөрчлөлт, таатай болон сөрөг хандлагуудыг дэлгэрэнгүй хэлэлцэн, харилцаа холбоо тогтоох, туршлагаа хуваалцлаа.

Санхүүгийн тайлан

Хүснэгт-4

| Хуурамт | Ам. доллар | % |
|---|-------------------|-------------|
| 2007 оны эцсийн үлдэгдэл | 90,553.14 | |
| Орлого | | |
| Төсвийн | 150,810.90 | 34% |
| Дотголлын | 1,381.38 | 3% |
| Нэн болон бусад орлого | 11,472.78 | 4% |
| НГ хөдөлж ирэнгэ бодлуулганы орлого | 41,377.40 | 9% |
| Дүн | 217,549.78 | 100% |
| Зардал | | |
| Төсвийн татвар | 146,649.27 | 40% |
| Татварын гэрээ хэлэлцээний үйл ажиллагаа | 77,893.95 | 8% |
| Сан бүрдүүлэл хэлэлцээний үйл ажиллагаа | 41,765.73 | 1% |
| Мэдээлэл, олон нийтийн харилцаа үйл ажиллагаа | 11,718.89 | 3% |
| Байгууллагын нэрэмжит байгуулал | 24,959.24 | 7% |
| Зөвлөлийн үйл ажиллагаа | 33,990.19 | 9% |
| Орлогийн байрны урьдчилгаа | 50,377.42 | 14% |
| Нөөцийн сан | 33,202.95 | 9% |
| Дүн | 370,521.04 | 100% |
| 2007 оны эцсийн үлдэгдэл | 37,672.88 | |

Дүрс зураг-4





Бидний тухай

Удирдах Зөвлөл

| | | |
|---------------|---------------|--------------|
| Б. Оюунбилэг | Л. Амарзаяа | А. Энхцэцэг |
| Д. Оюунцэцэг | Н. Дуламсүрэн | С. Оюунчимэг |
| С. Төгс-Оюун | Б. Мандухай | С. Дондов |
| Б. Наранцэцэг | Ш. Солонго | Д. Наран |
| Ш. Оюунгэрэл | Ө. Сарантуяа | Д. Нэргүй |
| | Х. Хулан | |

Зөвлөх гишүүд

Diana Van Maasdijk
Dr. Sheldon Severinghaus
Mary Rossabi

Талархал

МОНЭС-ийн хөгжил дэвшилд хувь нэмэр оруулсан Олон Улсын зөвлөх гишүүддээ талархал илэрхийлье.



МОНЭС-ын тэргүүн Ш. Цэвэлмаа, МУ-ын Анхны Тэргүүн Хатагтай

Гүйцэтгэх алба

Н. Чинчулуун, Захирал

chinchee@mones.org.mn

Л. Болор, Сан бүрдүүлэх хөтөлбөрийн Захирал

bolor@mones.org.mn

Б. Эрдэнэчимэг, Тэтгэлэг олгох хөтөлбөрийн зохицуулагч

chimgee@mones.org.mn

М. Мэндбаяр, Сан бүрдүүлэх хөтөлбөрийн зохицуулагч

mendee@mones.org.mn

Б. Байгалмаа, Олон нийтийн харилцаа, маркетингийн зохицуулагч

baigal@mones.org.mn

П. Даваанамжил, Санхүү, нягтлан бодогч

davaa@mones.org.mn

Ч. Саранчимэг, Дотоод ажлын зохицуулагч

saraa@mones.org.mn

ШАГНАЛ, ӨРГӨМЖЛӨЛ



SBN телевизийн "Үлэмжийн чанар-2007 өргөмжлөл" -өөр шилдэгийн шилдэг 5 эмэгтэйг тодруулсаны нэг нь МОНЭС-ийн захирал Н. Чинчулуун юм.



Манай хамт олон

Сайн Дурын Гишүүд

МОНЭС нь 10 аймагт сайн дурын төлөөлөгч, 60 гаруй сайн дурын гишүүдтэй. Орон нутгийн төлөөлөгчид МОНЭС-ын үйл ажиллагааг сурталчлах, мэдээлэл түгээх, эмэгтэйчүүдийн байгууллагуудаас төсөл хүлээн авч ирүүлэх, төслийн гүйцэтгэлд хяналт тавих зэргээр хувь хандив оруулдаг.



Хандивлагчдын нэрс

Хандивлагч

байгууллагууд

/1 саяаас дээш төгрөг/

Sheldon R. Severinghaus USA

SBN телевиз УБ

UBS телевиз УБ

Хандивлагч хувь хүмүүс

/100 001-250 000 төгрөг/

Mary and Morris Rossabi USA

Болор. Лэ УБ

Наран.Да УБ

Чинчулуун. На УБ

Төгс-Оюун.С УБ

Хандивлагч

байгууллагууд

/100 001-250 000 төгрөг/

Иргэдийн Альяанс Төв ТББ

Mine Info ХХК

Америк Монголын Хамтарсан

Сантис Боловсролын төв

Эйр Транс ХХК

Хандивлагч хувь хүмүүс

/50 001-100 000 төгрөг/

Diana van maasdijk

Лхам. Ж УБ

Рэнцэнханд. С УБ

Энхжаргал. Да УБ

Хандивлагч

байгууллагууд

/50 001-100 000 төгрөг/

Төв аймгийн Эмэгтэйчүүдийн

Зөвлөл

Дашчойлин хийд

Интерпресс хэвлэлийн

компани

Олон Улсын Хүүхдийн

Найрамдал зуслан

Охид эмэгтэйчүүдийг

хамгаалах "Гүнж" төв ТББ

MED Esthetica гоо сайхны

салон

Хар тамхи мансууруулах

бодисоос иргэдийг хамгаалах

нийгэмлэгийн дэргэдэх

эмэгтэйчүүдийн бүлэг

Lady төв

Хандивлагч хувь хүмүүс

/30 001-50 000 төгрөг/

Sarah

Байгалмаа. Ба УБ

Бадарч Даариймаа

Батмөнх. С УБ

Ганбаатар. С УБ

Ганхуяг.На УБ

Дашцэрэн. Ц УБ

Занаа. Ж УБ

Мандухай. Бу УБ

Нэргүй.Да УБ

Өсөхбаяр УБ

Цэрэндулам. Бү Завхан

Хандивлагч

байгууллагууд

/30 001-50 000 төгрөг/

Боловсрол Хамтын

Ажиллагааны Нийгэмлэг

Зэвсэгт Хүчний 336-р анги

Монголын Урлагийн Зөвлөл

Монголын Эмэгтэйчүүдийн Сан

Монфорте ХХК

МОНОС Улаанбаатар ХХК

Талын Монгол зоогийн газар

UB bulls фитнес төв

Хандивлагч хувь хүмүүс

/10 001-30 000 төгрөг/

Амарсанаа. ЖҮУБ

Баяр. Д УБ

Баярсайхан. Үр УБ

Булган. Мя Төв

Даваанамжил.Пү УБ

Дондов.Са УБ

Жаргал. Бө УБ

Идэрхурц,Гантөмөр

Мэндбаяр. Мө УБ

Норжин. Л УБ

Оюунбилэг. Ба УБ

Сумаахүү Говь-Алтай

Ундрах. Чи УБ

Таня. Н УБ

Төгсбуян. Б УБ

Төгсжаргал. Т УБ

Эрдэнэчимэг. Ба УБ

Хандивлагч

байгууллагууд

/10 001-30 000 төгрөг/

Akdeniz зоогийн газар

Арвай принт ХХК

Зэвсэгт Хүчний 311-р анги

Зэвсэгт Хүчний 015-р анги

Зэвсэгт Хүчний 124-р анги

Зэвсэгт Хүчний 303-р анги

Хар Тамхи Мансууруулах

Бодисоос Иргэдийг Хамгаалах

Нийгэмлэг

Гүрэн зоогийн газар

Ядуурлын эсрэг хөгжлийн сан

ТББ

Хандивлагч хувь хүмүүс

/5001-10 000 төгрөг/

Alison Rusinow

Алимаа. Ц УБ

Алтангэрэл УБ

Алтанчимэг. Ба УБ

Алтанчимэг. Ба УБ

Анударь. Га УБ

Ариунаа.Б Завхан

Ариунтунгалаг. Чо УБ

Баасанжаргал. Л Завхан

Баасанхүү. Ж УБ

Байгаль УБ

Балжир Туул УБ

Батжаргал УБ

Батчимэг. Х УБ

Баянжаргал. Д УБ

Баянцэцэг. Ба УБ

Баярмаа. То УБ

Баярсайхан. Б Завхан

Болдбаатар. С УБ

Болормаа. Т Багануур

Болор-Уянга Завхан

Болорчулуун.Эн УБ

Булганцэцэг. Д УБ

Бүлтэн.Б УБ

Бямбасүрэн. В Багануур

Галбадрах. Т УБ



Ганбаясах. Г УБ
 Гансүх. Ба УБ
 Ганчимэг. Д Завхан
 Гэрэлцэцэг. С Багануур
 Даваажав. П УБ
 Догмид. С УБ
 Догмиддулам. Сү УБ
 Дуламжав. М Завхан
 Ерболат. А
 Жавзандулам. Б Завхан
 Лхагвасүрэн. Ш УБ
 Лхам. У УБ
 Лхам-Эрдэнэ. Г Завхан
 Минжээ. Цэ УБ
 Молий. Ц Завхан
 Мөнхчимэг. Д УБ
 Нарантуяа. Дэ Төв
 Нарантуяа. На УБ
 Нарантуяа. С Завхан
 Нарантуяа. Со УБ
 Наранцэцэг. На УБ
 Нармандах. Л УБ
 Нацагдорж. Ц УБ
 Номуун. Э УБ
 Нэргүй. Б Багануур
 Ням. Д Завхан
 Нямдэлэг. Ш УБ
 Нямсүрэн. Ш Багануур
 Отгонцэцэг. Ав УБ
 Оюун. Б Завхан
 Оюун. Б УБ
 Оюунбат. Д Багануур
 Оюунбилэг. Ба УБ
 Оюунгэрэл. Ша УБ
 Оюундорж
 Оюунцэцэг. В УБ
 Оюунчимэг. С. УБ
 Пүрэвжаргал. Т Завхан
 Пүрэвжаргал. То Завхан
 Рэнцэн. С УБ
 Сайнхишиг. Г УБ
 Сарангэрэл. Ч Багануур
 Сарантуяа. ил Дорнод
 Сарнай Налайх
 Содбилэг УБ
 Солонго. Т УБ
 Сонинхүү Багануур
 Сүндэрээ. Ца Бэрцэцэг
 Сүрэнхорлоо. Дэ УБ
 Сүрэнхүү. С УБ
 Сэлэнгэ. С УБ

Сэрээтэр. Г УБ
 Төгс-Оюун. С УБ
 Төмөрхүү. Л УБ
 Төрболд УБ
 Тунгалаг. Д УБ
 Туул. Б УБ
 Туяа. Сэ УБ
 Ундарьяа. Тө УБ
 Үнэнч. С УБ
 Уранбилэг. У УБ
 Хажидсүрэн. Н УБ
 Хандсүрэн. Сү УБ
 Хишигбаяр. Э УБ
 Цогзолмаа. Т УБ
 Цолмон. Жа УБ
 Цэнгүүн УБ
 Цэнд-Аюуш. Да УБ
 Цэрэндэжид. Я Завхан
 Цэцгээ. Д УБ
 Цэцгээ. Ю УБ
 Цэцгээ. Д УБ
 Энхзаяа. Х УБ
 Энхтуяа. Б Завхан
 Энхтуяа. Н УБ
 Энхцэцэг. А УБ
 Эрдэнэцогт. Б УБ
 Эрдэнэцэцэг. Тө УБ
 Эрдэнэцэцэг. Тө УБ
 Эрдэнэцэцэг. Б УБ
 Эрдэнэчимэг. Ба УБ
 Эрдэнэчимэг. Д УБ
 Эрдэнэчимэг. Да УБ
 Эрдэнэчимэг. Д УБ
 Янжин Завхан
 Янжиндулам. Ш Завхан

**Хандивлагч
 байгууллагууд
 /5001-10 000 төгрөг/**

DHL ХХК
 Zericop ресторан
 Баян-Өлгий СУАТ
 Бороогоулд ХХК
 Дент-А-Мед шүдний эмнэлэг
 ДОХ-той тэмцэх Үндэсний сан
 Зэвсэгт Хүчний 336-р анги
 Монголын Улаан Загалмайн
 Нийгэмлэг
 Монголын Эмэгтэйчүүдийн
 Холбоо

МУБИС Биеийн тамирын
 сургууль
 Нийгмийн Даатгалын
 ажилтнуудын ҮЭ хороо
 РТТ ХХК
 Содтүм ХХК
 Сувд ХЗТ
 Төв аймгийн Эмэгтэйчүүдийн
 Зөвлөл
 Төмөр Замын Сайншанд 4-р
 анги 8,9,10-р хэсэг
 Төмөр Замын Сүхбаатар өртөө
 Төмөр Замын Сүхбаатар өртөө
 Ховд аймгийн ХХС
 Ховд аймгийн ЦТС
 Хүүхдийн төлөө Амьдрах ухаан
 төв
 Хэнтий аймгийн ЦТ Сүлжээ

**Хандивлагч хувь хүмүүс
 /1001-5000 төгрөг/**

Elizebeth
 Kevin Nolan Нью Йорк
 Thomas Sa УБ
 Адьяа. Ж УБ
 Адьяахүү. Б Хэнтий
 Алдармаа. Са Хөвсгөл
 Алимаа Бэрцэцэг
 Алтангэрэл. А УБ
 Алтанзул. С УБ
 Алтаннавч. п Дорнод
 Алтантуяа. Ба УБ
 Алтанцэцэг. Б Бэрцэцэг
 Алтанцэцэг. Ба УБ
 Алтанцэцэг. Ж ХЭҮТ
 Алтанцэцэг. М УБ
 Алтанцэцэг. Ж УБ
 Алтанчимэг. Ч УБ
 Алтаншагай. Э Дорноговь
 Амараа. М УБ
 Амарзаяа. Га УБ
 Амарсайхан УБ
 Амарсайхан. П УБ
 Амартүвшин. А УБ
 Амгалан. До Хөвсгөл
 Амгалан. Тэ УБ
 Ариунаа. Н
 Ариунаа. Н УБ
 Ариунаа. Цэ УБ
 Ариунболор. Д УБ
 Ариунжаргал. А УБ

Баасанжав. Г УБ
 Баатархүү. Та УБ
 Бадамсүрэн. Ца УБ
 Бадамханд. Л Багануур
 Бадамцэцэг УБ
 Бадамцэцэг. Лу УБ
 Бадамцэцэг. Дэ УБ
 Бадрал. С УБ
 Бадрууш. Д УБ
 Байгалмаа. Б УБ
 Бат-Өлзий. Б УБ
 Батсайхан. Г Дорноговь
 Батсуурь. И УБ
 Батсүх. Ш УБ
 Батхишиг. Б УБ
 Батхүү. Б Дорноговь
 Батцэцэг. Д Бэрцэцэг
 Бат-Эрдэнэ. Га УБ
 Баяр. Б УБ
 Баярмаа. М УБ
 Баярмаа. Л УБ
 Баярсайхан УБ
 Баярцэнгэл. Ш Дорноговь
 Билэгсайхан. Н УБ
 Болормаа. Цэ Ховд
 Бүжин. Да Дорнод
 Булгантамир. Э УБ
 Бумнасан. Ма УБ
 Бурмаа. Цо Хөвсгөл
 Бэхбат. Б УБ
 Бямбаа. Пү Ховд
 Бямбадорж. Л
 Бяцхандай УБ
 Галаазаграа. Аю
 Ганбат. Пу Бэрцэцэг
 Ганболд. Чо Бэрцэцэг
 Гантөмөр. На УБ
 Гантулга. Г УБ
 Ганхуяг. Д УБ
 Ганхуяг. Д Дорноговь
 Ганцэцэг. Ба Бэрцэцэг
 Ганцэцэг. Д Багануур
 Ганчулуун. Га УБ
 Гоёлцэцэг. Р УБ
 Гүндэгмаа. З Багануур
 Гэрэл. Л УБ
 Гэрэлмаа. Г УБ
 Гэрэлтуяа. Га Сэлэнгэ
 Гэрэлцацрав. Д УБ
 Даариймаа УБ
 Даваажаргал. Гү

Даваасамбуу. Ц Дорноговь
 Даваасүрэн. Б УБ
 Даваасүрэн. С УБ
 Дагзмаа. Б УБ
 Дашдэмбэрэл. Га
 Дашцэрэн. Л Хөвсгөл
 Догмиддулам. С УБ
 Долгор. А УБ
 Долгор. Аю УБ
 Долгорсүрэн. Го УБ
 Доржмаа. Т УБ
 Доржханд. Ха УБ
 Дуламсүрэн. Да УБ
 Дуламсүрэн. На УБ
 Дуламцоо Дорнод
 Дулмаа. Га Бэрцэцэг
 Дүүрэнбаяр. С Дорноговь
 Дэжид. Ц УБ
 Дэмбэрэлмаа. До
 Жаргалсайхан УБ
 Золзаяа УБ
 Зол-Эрдэнэ. Г УБ
 Итгэл. О УБ
 Ичинноров. Л УБ
 Лусмаа. И Бэрцэцэг
 Лхагвадулам. Л УБ
 Лхагважав. Са Ховд
 Лхагвасүрэн. Ш УБ
 Маруя. Ц УБ
 Мөнхбаатар. Ми
 Мөнхбаатар. Сэ УБ
 Мөнхбат. Гү Бэрцэцэг
 Мөнхжавхлан. Б
 Мөнхжаргал. С Багануур
 Мөнхжаргал. Ня УБ
 Мөнхнасан. Ба УБ
 Мөнх-Очир. Дэ Бэрцэцэг
 Мөнхцэцэг УБ
 Мөнхцэцэг. Б УБ
 Мөнхчулуун. Га УБ
 Мягмарсүрэн. З УБ
 Н. Ариунаа УБ
 Наранбаатар. Б УБ
 Нарантунгалаг. Ц
 Нарантуяа. Ра Бэрцэцэг
 Нарантуяа. До УБ
 Нарантуяа. Чо Бэрцэцэг
 Наранцэцэг. Ч Багануур
 Наранчимэг. Б Бэрцэцэг
 Насанжаргал. А Багануур
 Нийслэл. О Багануур

Номин. Л УБ
 Номин. Н УБ
 Нямбаяр. С УБ
 Нямтуяа. Д Багануур
 Нямхүү. Ми УБ
 Одгэрэл. Са Бэрцэцэг
 Одончимэг. Л Бэрцэцэг
 Олончимэг. Д УБ
 Отгонбаяр. М УБ
 Отгонбаяр. Ч УБ
 Отгонжаргал. Сү УБ
 Отгонтуйяа. Б УБ
 Отгонцэцэг. Г УБ
 Оюунбат. Р УБ
 Оюунбаяр. Ё Багануур
 Оюунгэрэл. Са УБ
 Оюундулам. Да Завхан
 Оюундэлгэр. Жа
 Оюунжаргал. Э Хөвсгөл
 Оюунцэцэг. Я Багануур
 Оюунчимэг. Ба Ховд
 Оюунчимэг. Л УБ
 Оюунчимэг. Л УБ
 Оюунчимэг. Ц УБ
 Оюунчимэг. Ч УБ
 Өлзийсайхан. Б Бэрцэцэг
 Пүрэвдавга. Ба Бэрцэцэг
 Пүрэвсүрэн. Д Хөвсгөл
 Пүрэвсүрэн. Д УБ
 Пүрэвсүрэн. Д УБ
 Раднаа. Гэ Бэрцэцэг
 Сансарбаяр. Ч Дорноговь
 Сансартуяа. Ч УБ
 Санчо. Б УБ
 Сарангэрэл. Л Дорноговь
 Сарангэрэл. Ту Бэрцэцэг
 Сарантуяа. Г УБ
 Сарантуяа. Ч Бэрцэцэг
 Саранцэцэг. Г УБ
 Саруул. С УБ
 Сугар. Б УБ
 Сугар. С УБ
 Сугарбаатар. Г Номт зөрлөг
 Сугарсүрэн. Тө УБ
 Сумьяа. Ч Бэрцэцэг
 Сумьяасүрэн. Ч УБ
 Сүндэрмаа. Ба Дархан
 Сүхбат. Сү Бэрцэцэг
 Сэржээ. К УБ
 Сэрээтэр. н УБ
 Тайванжаргал. Т УБ